



МОНГОЛ АЛТ ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

2026 оны 04 сарын 27-ны өдөр

№ 01

Дархан-хот

Компанийн 2025 оны санхүүгийн тайлан,
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн
гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.11, 62 дугаар зүйлийн 62.1.9, “Монгол алт” ХК-ийн дүрмийн 8.4.9 дэх заалт, Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01 тоот тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монгол алт” ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн дүгнэлтийг баталсугай.

2. Тус компанийн 2026 оны бизнес төлөвлөгөөг баталж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг шинээр байгуулагдах Төлөөлөн Удирдах Зөвлөлд, бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал (М.Цолмон)-д тус тус үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Л.АМАРСАНАА





МОНГОЛ АЛТ ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

2026 оны 04 сарын 27-ны өдөр

№ 02


Дархан хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.8, 46.10 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.2.7 дахь заалт, "Монгол Алт" ХК-ийн дүрмийн 22.1 дэх заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн хурлын тооллогын комиссын 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ээлжит хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар нэгж хувьцаанд 500 (таван зуун) төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар тогтсугай.
2. Ногдол ашгийг холбогдох журмын дагуу хугацаанд нь олгож, тайланг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирал (М.Цолмон)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.АМАРСАНАА



МОНГОЛ АЛТ ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

2026 оны 04 сарын 27-ны өдөр

№ 03

Дархан хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.4, "Монгол алт" ХК-ийн дүрмийн 8.4.7 дахь заалт, Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 03 тоот тогтоолыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ НЬ:

1. "Монгол алт" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгосугай. Үүнд:

1.1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр:

1.1.1. Л.Амарсанаа

1.1.2. М.Цолмон

1.1.3. М.Оюун

1.1.4. Ж.Мөнхтөр

1.1.5. А.Болор-Эрдэнэ

1.1.6. Б.Саруул

1.2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр:

1.2.1. О.Лувсаншарав

1.2.2. С.Дорждэрэм

1.2.3. Б.Базарсад

2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлыг 2026 оны 06 дугаар сард багтаан хуралдуулж түүний дэргэдэх хороодыг байгуулах ажлыг шинээр сонгогдсон ТУЗ-ийн гишүүдийн оролцоотойгоор зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (М.Цолмон)-д үүрэг болгосугай.

3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн анхны хурлыг зохион байгуулж, компанийн засаглалын журам, баримт бичгүүдийг хэлэлцэх, цаашид хууль тогтоомж, компанийн дүрэм, компанийн засаглалын журмуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нийт гишүүдэд үүрэг болгосугай.

4. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шинээр сонгогдсон ердийн болон хараат бус гишүүдийн талаарх мэдээллийг Хувьцаа эзэмшигчид, Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид мэдэгдэхийг Гүйцэтгэх захирал (М.Цолмон)-д үүрэг болгосугай.

5. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан “Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох тухай” “Монгол алт” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 03 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.АМАРСАНАА



МОНГОЛ АЛТ ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

2026 оны 04 сарын 27 ны өдөр

№ 04

Дархан хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны зардлын төсөв,
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга, нарийн бичийн дарга,
гишүүдийн урамшууллын хэмжээг тогтоох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, “Монгол алт” ХК-ийн дүрмийн 8.7 дахь хэсэг, Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 04 тоот тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Монгол алт” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хэвийн үйл ажиллагаа хангах 2026 оны зардлын төсвийг 21,120,000.0 (хорин нэгэн сая нэг зуун хорин мянга) төгрөгөөр тогтоосугай.
2. “Монгол алт” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга, гишүүдийн урамшууллын хэмжээг энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсугай.
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах зардлыг санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал (М.Цолмон)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Л.АМАРСАНАА



“Монгол алт” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2026 оны
04 дүгээр сарын 27-ны өдрийн №1 тоот тогтоолын нэгдүгээр хавсралт

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ГИШҮҮДИЙН УРАМШУУЛЛЫН ХЭМЖЭЭ**

№	ТУЗ-ийн гишүүний нэр	1 сарын урамшуулал /төг/	1 жилийн урамшуулал /төг/
1	Ердийн гишүүн ТУЗ-н дарга	200,000.0	2,400,000.0
2	Ердийн гишүүн	180,000.0	2,160,000.0
3	Ердийн гишүүн	180,000.0	2,160,000.0
4	Ердийн гишүүн	180,000.0	2,160,000.0
5	Ердийн гишүүн	180,000.0	2,160,000.0
6	Ердийн гишүүн	180,000.0	2,160,000.0
7	Хараат бус гишүүн	180,000.0	2,160,000.0
8	Хараат бус гишүүн	180,000.0	2,160,000.0
9	Хараат бус гишүүн	180,000.0	2,160,000.0
10	Нарийн бичгийн дарга	120,000.0	1,440,000.0
	Нийт		21,120,000.0

оОо